



Independent
Project
Accountability
Mechanism

Комплайнсын үнэлгээний тайлан

Улаанбаатар-Дарханы зам

ЕСБХБ-ны төслийн дугаар: 50766

Кейс 2022/01

2023 оны 4-р сар

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХБХМ) нь Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны хариуцлагын механизм юм. ТХБХМ нь банкнаас санхүүжүүлсэн төслөөс хохирол учруулсан, учирч болзошгүй гэж үзэж буй хувь хүн, байгууллагаас гаргасан асуудлыг хараат бусаар хянаж үнэлдэг. Энэхүү механизмын зорилго нь төсөлд оролцогч талуудын дунд нийгэм, байгаль орчин болон ил тод байдлын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; банк нь байгаль орчин ба нийгмийн бодлого болон мэдээллийн хүртээмжийн бодлогынхоо төсөлд хамааралтай заалтуудыг мөрдөж ажилласан эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд эдгээр бодлогыг зөрчсөн аливаа зөрчлийг арилгахын зэрэгцээ цаашид зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилготой юм. Нөлөөлөлд өртсөн этгээд нь эдгээр хоёр чиг үүрэг эсхүл тэдгээрийн аль нэгийг ашиглах боломжтой.

ТХБХМ-ын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй шууд холбогдож эсвэл www.ECBXB.com/project-finance/lpam.html цахим хуудаст зочилно уу.

Холбоо барих Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХБХМ) Европын сэргээн босголт хөгжлийн банк One Exchange Square London EC2A 2JN Утас: +44 (0)20 7338 6000 И-мэйл: lpam@ebrd.com	ТХБХМ-д хэрхэн гомдол гаргах вэ? ЕСБХБ төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн талаар санаа зовниж буй асуудлуудыг цахим шуудангаар, утсаар болон бичгээр эсвэл цахим хэлбэрээр дараах хаягт илгээж болно. □ https://www.ebrd.com/project-finance/lpam.html
--	--

Агуулга

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	4
ТОВЧ ХУРААНГУЙ	5
1. Ерөнхий мэдээлэл.....	7
1.1. Хүсэлт	7
1.2. Төсөл ба түүний өнөөгийн байдал.....	7
1.3 ТХБХМ-аас явуулсан кейсийн өнөөг хүртэлх боловсруулалт	8
2. ЕСБХБ-ны удирдлагын хариу.....	11
3. Комплайнсын үнэлгээний үр дүн	13
3.1 Улаанбаатар-Дарханы зам төсөлтэй холбоотой учирч болзошгүй хор хохирлын талаар	14
3.2 Эдийн засгийн дайжилтын тухайд.....	18
3.3 Байгаль орчин, нийгмийн асуудалд хийгдэж буй менежмент, мониторингийн талаар	19
3.4 Оролцогч талуудын оролцоог хангах талаар.....	20
3.5 Нөлөөлөлд өртсөн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар.....	22
ХАВСРАЛТ 1. КОМПЛАЙНСЫН ШАЛГАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР.....	23

Өөрөөр нарийвчлан заагаагүй бол энэ тайланд том үсгээр бичсэн нэр томьёо нь 2019 оны Төслийн хариуцлагын бодлогод заасан нэр томьёог илтгэнэ.

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АХБ	Азийн Хөгжлийн Банк
МХБ	ЕСБХБ-ны мэдээллийн хүртээмжийн бодлого
ЕСБХБ	Европын сэргээн босголт хөгжлийн банк
ЕРС	Инженерчлэл, Худалдан авалт, Барилга
БОНУАТ	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө
БОННУ	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОНМТ	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө
БОННБ	Байгаль орчин, нийгмийн бодлого
ОУСТ	Олон улсын сайн туршлага
ТХБХМ	Төслийн бие даасан хариуцлагын механизм
км	километр
ГЧНШХ	Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх тогтолцоо
ГЧНШТ	Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө
ХХК	Төрөл :Хязгаарлагдмал хувьцаат компани
МҮАТ	Менежментийн үйл ажиллагааны төлөвлөгөө
ЗТЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ТХБ	2019 оны Төслийн хариуцлагын бодлого
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ГШ	Байгаль орчин, нийгмийн бодлогын гүйцэтгэлд тавигдах шаардлага
ТХББ	Төслийн хураангуй баримт бичиг
ОТОХТ	Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө
УБ-ДАРХАНЫ ЗАМ	Улаанбаатар-Дарханы зам

Товч хураангуй

Хүсэлт

[Төслийн хариуцлагын хараат бус механизм](#) (ТХБХМ) нь 2022 оны 3-р сарын 31-ний өдөр Монгол улсын Төв аймгийн нутаг, Улаанбаатар-Дарханы зам дагуу 108 км-т байрлах Дуган хад амралтын газрын эзэн Лханаажавын Бүрэнтөгсөөс [хүсэлт](#) хүлээн авсан. Тэрээр ЕСБХБ-ны [Улаанбаатар-Дарханы зам \(50766\)](#) дараах сөрөг нөлөөл үзүүлж буй гэж үзсэн, үүнд (i) тус зам нь амралтын газарт хүрэх цорын ганц зам бөгөөд авто замын өргөтгөлийн ажлаас үүдэн 2019 оны 8-р сараас хойш зам хаалттай байснаас үүдэн бизнест нь үзүүлсэн сөрөг нөлөөлөл, мөн (ii) бүрэн баригдаагүй замаас үүдэх орон нутгийн аюулгүй байдал, хангалтгүй түр замаас үүдэлтэй осол, аваараас үүдэх сөрөг нөлөөллийг тус тус дурдсан байна. ЕСБХБ нь төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл дээр хангалттай ажиллахгүй байгаа, мөн хүсэлт гаргагч болон түүний орон нутгийн иргэдэд төслөөс үзүүлэх хор хохирлыг шийдвэрлэж чадаагүй хэмжээн хүсэлтэд онцолсон байна. Үүнтэй адил гомдлыг Азийн Хөгжлийн банкны хариуцлагын механизмд мөн илгээсэн байна.

Төсөл

[Улаанбаатар-Дарханы зам \(50766\)](#) төслийн хүрээнд Монгол улсын авто замын сүлжээний чухал судас, Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын нэг хэсэг болох, Монгол Улсын хойд хэсэгт байрлах Улаанбаатараас тус улсын хоёр дахь том хот болох Дархан хот хүртэлх 202 км авто замыг өргөтгөх ажлыг хийх юм. Төслийн хураангуй баримт бичигт зааснаар ЕСБХБ-ны төсөл нь авто замыг дөрвөн эгнээ болгон өргөтгөн сайжруулах ажил бүхий II үе шатыг хамарч буй юм. Нэгдүгээр үе шат нь Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа бөгөөд одоо байгаа хоёр урсгалтай замыг сайжруулан засварлах ажлыг хамарч буй юм. Төслийг Монгол Улсын Зам тээвэр, хөгжлийн яам (харилцагч) хэрэгжүүлж байна. Төсөл нь ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөлөөс 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан 137 сая ам.доллар хүртэлх анхны зээл, мөн төслийн I, II үе шатыг бүтцийн хувьд уялдуулах шаардлагаас үүдэлтэй нэмэлт зардлыг санхүүжүүлэх зорилгоор тус зөвлөлөөс 2022 оны 2-р сарын 23-ны өдөр батлагдсан 20 сая ам.доллар хүртэлх хоёр дахь зээлээс тус тус бүрдэж буй юм. Төслийн зорилго нь дотоодын болон олон улсын хөдөлгөөний эрэлт хэрэгцээг хангахуйц хэмжээнд авто замын хүчин чадлыг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг сайжруулахад оршино. Зээлийн статус батлагдсан хэмээх ангилалд байна.

Комплайнсын үнэлгээний үе шат

Комплайнсын үнэлгээний үе шатанд ТХБХМ нь Комплайнсын шалгалт явуулж эхлэхэд тавигдах шалгуурыг хангасан эсэхийг тодорхойлохын тулд урьдчилсан үнэлгээ хийдэг. Энэхүү кейстэй холбогдуулан ТХБХМ нь 2022 оны 9-р сарын 22-ноос 2022 оны 12-р сарын 29-ний хооронд үнэлгээ хийсэн. Ажлын даалгавар дээр санал хүсэлт авах үүднээс тайлангийн төслийг хүсэлт гаргагч, банкны удирдлага болон харилцагчид тараасан. ТХБХМ-д харилцагчаас бусад хоёр талаас саналаа ирүүлсэн.

Тайлангийн эцсийн хувилбарт аль болох ирүүлсэн саналыг тусгасан бөгөөд ТХБХМ-ын комплайнсын үнэлгээний үе шатанд гарсан урьдчилсан үр дүнг танилцуулсан болно.

Дүгнэлт

2019 оны Төслийн хариуцлагын бодлогын 2.6 (м) хэсэгт заасан Комплайнсын үнэлгээний заалтуудын дагуу, [Кейс 2022/01](#) нь тогтоосон шалгуурыг хангасан гэж ТХБХМ үзэж байна. Учир нь:

- i. Урьдчилсан байдлаар авч үзэхэд төсөл нь хүсэлт гаргагчид (эсвэл, өөр бол Төслийн нөлөөлөлд өртсөн холбогдох хүмүүст) шууд болон шууд бус болон материаллаг хохирол учруулсан буюу учруулах магадлалтай гэж харагдаж байна; мөн
- ii. Банк нь Байгаль орчин, нийгмийн бодлогын заалтууд (үүнд Банкнаас харилцагчийн хүлээсэн амлалтад хяналт тавихыг шаардсан заалтыг оруулаад); эсвэл уг төсөл батлагдах үед мөрдөгдөж байсан Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)-ын төсөлтэй холбоотой заалтуудыг дага мөрдөөгүй байж болзошгүй байна.

Тиймээс, ТХБХМ Хавсралт 1-д санал болгосон ажлын даалгаврын хүрээнд комплайнсын шалгалтыг үргэлжлүүлэхийг зөвлөж байна.

Комплайнсын шалгалтын хамрах хүрээнд зам хаагдсан, түр замын аюулгүй байдал хангаагүйгээс үүдэн эдийн засгийн дайжилт үүссэн гэх гомдолтой холбоотойгоор ЕСБХБ нь тус банкны 2014 оны БОНБ-д заасан ерөнхий заалтууд болон Гүйцэтгэлийн шаардлага 1, 4 ба 10-ыг биелүүлсэн эсэхийг шалгах болно.

ТХБХМ нь энэ үе шатанд оролцсон талуудад талархал илэрхийлж буй бөгөөд комплайнсын шалгалтын явцад тэдэнтэй үргэлжлүүлэн хамтран ажиллах болно.

Дараагийн алхмууд

Энэхүү комплайнсын шалгалтын үнэлгээний тайлан, түүний Хавсралт 1-д танилцуулсан шалгалтын ажлын даалгаврыг Захирлуудын зөвлөл болон Ерөнхийлөгчид мэдээлэл болгон хүргүүлж, бүх талуудтай хуваалцаж, [ТХБХМ-ын Кейс бүртгэл](#)ийн системд [Case 2020/01](#) гэх хавтаст англи, монгол хэл дээр ил болгоно.

Ажлын даалгаврын дагуу комплайнсын шалгалтыг энэхүү тайланг ил болгосны дараа шууд эхлүүлнэ.

ТХБХМ нь комплайнсын багийн одоогийн ачаалал, холбогдох баримт бичгүүдийг орчуулахад шаардагдах хугацаанаас үүдэн комплайнсын шалгалтын тайлангийн төслийг боловсруулж дуусгах хугацааг нарийвчлан гаргаж өгөх боломжгүй байна. Комплайнсын шалгалтыг аль болох шуурхай явуулахын тулд бүхий л хүчин чармайлт гаргана. Оролцогч бүх талуудад шалгалтын статусыг байнга мэдэгдэж явах бөгөөд тайлангийн төслийг боловсруулж дуусах хугацааг тооцмогцоо мөн мэдэгдэх болно.

1. Ерөнхий мэдээлэл

1.1. Хүсэлт

2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Монгол улсын Төв аймгийн Улаанбаатар-Дархан хотын замын 108 километрт байрлах Дуган хад амралтын газрын эзэн хатагтай Лханаажавын Бүрэнтөгс (хүсэлт гаргагч) ТХБХМ-д хүсэлт гаргасан. Тэрээр ЕСБХБ-ны [Улаанбаатар-Дарханы зам \(50766\)](#) дараах сөрөг нөлөөл үзүүлж буй гэж үзсэн, үүнд (i) тус зам нь амралтын газарт хүрэх цорын ганц зам бөгөөд авто замын өргөтгөлийн ажлаас үүдэн 2019 оны 8-р сараас хойш зам хаалттай байснаас үүдэн бизнест нь үзүүлсэн сөрөг нөлөөлөл, мөн (ii) бүрэн баригдаагүй замаас үүдэх орон нутгийн аюулгүй байдал, хангалтгүй түр замаас үүдэлтэй осол, аваараас үүдэх сөрөг нөлөөллийг тус тус дурдсан байна. Энэ байдлаас үүдэн түүний зочид буудлын захиалга огцом буурч, орлогоо алдаж, улмаар өр нь нэмэгджээ.

Цаашилбал, хүсэлт гаргагч нь замын ажил маш удаашралтай явагдаж байгаа бөгөөд ажлын явц дуусах хугацааны талаар ямар нэг мэдээлэл өгөөгүй хэмээсэн. Хүсэлтэд дурдсанаар хэрэв ажил илүү удааширч, зам хаагдсан хэвээр байвал амралтын газрын үйл ажиллагаа бүрэн зогсоно гэжээ.

Эцэст нь, хүсэлт гаргагч нь орон нутгийн бусад аж ахуйн нэгж, айл өрхүүд, тэдгээрийн дотор 30 жуулчны бааз, зургаан малын ферм, зургаан зоогийн газар, нэг амьтны хүрээлэн, мөн 100 гаруй газар тариалангийн компани, зам дагуу байрлах олон мянган өрхүүд тус замын ажлын сөрөг нөлөөлд өртсөн байна гэж мэдэгджээ. Хүсэлт гаргагч нь Зам, тээврийн хөгжлийн яам болон ЕСБХБ-инд хандсан боловч хариу өгөөгүй гэж тайлбарласан.

Хүсэлт гаргагч нь үүнтэй төстэй гомдлыг Азийн Хөгжлийн Банкны хариуцлагын механизмд давхар илгээсэн байна. Хүсэлт гаргагч нь ТХБХМ-тай харилцахдаа асуудлыг шийдвэрлэх ба комплайнсын хяналт (шалгалт)-ын ажиллагааг сонирхож байгаагаа илэрхийлсэн байна.

1.2. Төсөл ба түүний өнөөгийн байдал

[Улаанбаатар-Дарханы зам \(50766\)](#) төслийн хүрээнд Монгол улсын авто замын сүлжээний чухал судас, Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын нэг хэсэг болох, Монгол Улсын хойд хэсэгт байрлах Улаанбаатараас тус улсын хоёр дахь том хот болох Дархан хот хүртэлх 202 км авто замыг өргөтгөх ажлыг хийх юм. Одоогийн зам нарийхан, нүхтэй, шаардлагатай тээврийн хөдөлгөөнийг авах боломжгүй байна. Төслийн зорилго нь дотоодын болон олон улсын хөдөлгөөний эрэлт хэрэгцээг хангахуйц хэмжээнд авто замын хүчин чадлыг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг сайжруулахад оршино.

[Төслийн хураангуй баримт бичиг \(ТХББ\)](#)-т заасанчлан, ЕСБХБ-ны төсөл нь авто замыг дөрвөн эгнээ болгон өргөтгөн сайжруулах ажил бүхий II үе шатыг хамарч буй юм. Нэгдүгээр үе шат нь Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа бөгөөд одоо байгаа хоёр урсгалтай замыг сайжруулан засварлах ажлыг хамарч буй юм. Төслийг Монгол Улсын Зам тээвэр, хөгжлийн яам хэрэгжүүлж байна.

Улаанбаатар-Дарханы зам (50766) төсөл нь ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөлөөс 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан 137 сая ам.доллар хүртэлх анхны зээл, мөн төслийн I, II үе шатыг бүтцийн хувьд уялдуулах шаардлагаас үүдэлтэй нэмэлт зардлыг санхүүжүүлэх зорилгоор тус зөвлөлөөс 2022 оны 2-р сарын 23-ны өдөр батлагдсан 20 сая ам.доллар хүртэлх хоёр дахь зээлээс тус тус бүрдэж буй юм.

2014 оны Байгаль орчин, нийгмийн бодлогын дагуу байгаль орчин, нийгмийн нөлөөллийн иж бүрэн үнэлгээ хийх, үүнд олон нийтийн зөвлөгөөн хийж, Захирлуудын зөвлөлөөр батлуулахаас 120 хоногийн өмнө ЕСБХБ-наас нийтэд ил болгох шаардлагатай буюу А ангилалд тус төсөл хуваарилагдсан байна.

Төслийн баримт бичигт зааснаар төслийн үйл ажиллагаа нь тодорхой хэмжээнд эдийн засгийн дайжилт үүсгэж, барилга байгууламж буулгахад хүргэх боловч хүмүүсийн орон байр, үл хөдлөх хөрөнгөд нөлөөлөхгүй гэсэн байна. Төслийг ЕСБХБ-ын гүйцэтгэлийн шаардлагад¹ нийцсэн бүтэцтэй болгох зорилгоор байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний нийтэд ил болгосон мэдээллийн багцад тодорхойлсон газар болон амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг зохицуулах газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн хүрээ гэх баримт бичгийг боловсруулсан байна.

1.3 ТХБХМ-аас явуулсан кейсийн өнөөг хүртэлх боловсруулалт

1.3.1. Хүсэлтийн бүртгэл

Хүсэлт нь ТХБ-ын 2.2 (b) хэсэгт заасан бүртгэлийн шалгуурыг хангасан, мөн тус бодлогын 2.2 (c) хэсэгт заасан онцгой тохиолдлын аль нь ч энэ шатанд хамаарахгүй гэж үзсэн тул түүнийг 2022 оны 5-р сарын 17-ны өдөр бүртгэж авсан. Хүсэлтийг бүртгэсэн нь дараах шалгуурыг хангасан болохыг тогтоож буй захиргааны шинжтэй алхам юм.

- шаардлагатай бүх мэдээллийг өгсөн;
- Байгаль орчин, нийгмийн бодлоготой холбогдуулан тус банкны хүлээх тодорхой үүргүүд болон/эсвэл мэдээллийн хүртээмжийн бодлогын төсөлд хамааралтай тодорхой заалтуудтай холбоотой асуудлыг хөндсөн; мөн
- банкнаас баталсан төсөлтэй холбоотой хүсэлт бөгөөд төсөл дэх банкны санхүүгийн оролцоо байхаа болсон өдрөөс хойш 24 сарын дотор тус хүсэлтийг ирүүлсэн тус тус болно.

1.3.2. Үнэлгээ

ТХБ-д заасан шаардлагын дагуу үнэлгээний үе шатанд ТХБХМ-ын зүгээс хүсэлтэд хөндсөн асуудлуудыг илүү сайн, ойлгож авах, мөн талууд асуудлыг шийдвэрлэх эсвэл комплайнсын ажиллагаанд оролцох сонирхолтой байгаа эсэхийг үнэлэхэд чиглэж ажилласан.

Энэ үе шатанд ТХБХМ нь хүсэлт гаргагч, банкны удирдлага, харилцагчийн хуваалцсан бичиг баримттай танилцаж, яамны удирдлагууд болон хүсэлт гаргагчтай биечлэн уулзав.

¹ГЧНШХ, эцсийн хувилбар, <https://www.ebrd.com/work-with-us/projects/esia/ulaanbaatar-darkhan-road-project.html>

Банкны удирдлага, харилцагч болон хүсэлт гаргагчтай хамтран ажилласны дараа ТХБХМ асуудлыг шийдвэрлэх санаачилгыг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэн кейсийг комплайнс үнэлгээнд шилжүүлсэн.

2022 оны есдүгээр сарын 23-нд гаргасан үнэлгээний тайланд гаргасан шийдвэр, үндэслэлийн талаар талуудад мэдэгдэж,² комплайнсын үйл явцад хамруулах шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоолгохоор хүсэлтийг комплайнсын багт шилжүүлсэн.

1.3.3. Комплайнсын үнэлгээ

Комплайнсын үнэлгээний үйл явц нь уг хүсэлтийг комплайнсын шалгалтад хамруулах шалгуурыг хангаж буй эсэхийг үнэлэхэд оршино. Шалгалтын ажиллагааг эхлүүлэхийн тулд тухайн кейст холбогдох шалгуурыг хангасан гэх үндэслэл тогтоогдсон байх ёстой. Тиймээс кейс 2022/01-ийн хувьд уг төсөлтэй холбогдуулан ТХБХМ нь дараах асуудал байж болзошгүй эсэхийг тогтоохоор ажилласан, үүнд:

- i. Төсөл нь хүсэлт гаргагчид (эсвэл өөр бол, төслийн нөлөөлөлд өртсөн холбогдох хүмүүст) шууд болон шууд бус болон материалаг хохирол учруулсан буюу учруулах магадлалтай байхаар харагдаж буй; мөн
- ii. Банк нь Байгаль орчин, нийгмийн бодлогын заалтууд (үүнд Банкнаас харилцагчийн хүлээсэн амлалтад хяналт тавихыг шаардсан заалтыг оруулаад); эсвэл уг төсөл батлагдах үед мөрдөгдөж байсан Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)-ын төсөлтэй холбоотой заалтуудыг дага мөрдөөгүй байж болзошгүй байна.

Комплайнсын үнэлгээний үе шат нь үнэлгээний тайлан гарсан өдрөөс хойш ажлын 60 хоногт явагдах стандарт хугацаатай. Боловсруулалтыг чанарыг хангах эсвэл баримт бичгийн орчуулга хийгдэх шаардлагатай бол энэ хугацааг сунгаж болно. Энэ үе шатны төгсгөлд ТХБХМ-ын хийсэн дүгнэлт, мөн тухайн кейс шалгуурыг хангаж буй эсэхтэй холбогдуулан дараах хоёрын аль нэг хариуг агуулсан комплайнсын үнэлгээний тайланг бэлтгэнэ. Үүнд:

- 2.6 (b)-д заасан шалгуурыг хангасан болохыг тогтоосон тул тухайн кейсийг комплайнсын шалгалтыг үргэлжлүүлэхийг зөвлөх. Энэ тохиолдолд, комплайнсын үнэлгээний тайланг комплайнсын шалгалтын ажлын даалгавартай хамт Захирлуудын зөвлөл болон Ерөнхийлөгчид мэдээлэл болгон хүргүүлнэ.
- 2.6 (b)-д заасан шалгуурыг хангаагүй болохыг тогтоосон тул тухайн кейсийг хаахыг зөвлөх. Энэ тохиолдолд, комплайнсын үнэлгээний тайланд тусгасан дүгнэлтийг Захирлуудын зөвлөлд оруулж батлуулдаг.

Комплайнсын үнэлгээг 2022 оны 9-р сарын 23-наас эхлүүлсэн бөгөөд нэмэлт баримт бичгийг орчуулах боломж олгох, мөн ЕСБХБ-ны төв офист жилийн эцсийн амралтын хугацаатай давхацсан тулд дөрвөн долоо хоног сунгах шаардлагатай болсон. Энэхүү комплайнсын үнэлгээний тайланг 2023 оны 2-р сарын 10-ны өдөр талуудад тарааж, ажлын 10 хоногт багтаан санал болгож буй ажлын даалгаврын талаар санал бодлоо ирүүлэх боломжоор хангасан. Банкны удирдлагаас тавьсан хүсэлтийн дагуу санал ирүүлэхэд олгосон уг хугацааг ажлын 10 хоногоор нэмж сунгасан.

²<https://www.ebrd.com/work-with-us/projects/ipam/2022/01.html>.

ТХБХМ нь банкны удирдлага болон хүсэлт гаргагчдаас³ ирсэн саналыг хянан үзэж, тэдгээрийн нэг бүрийг зохих ёсоор харгалзан үзэн тайланг эцэслэсэн.

Эцсийн хувилбарыг ТХБХМ-ын нийтэд нээлттэй бүртгэлд ил болгохын өмнө Захирлуудын зөвлөл болон Ерөнхийлөгчид мэдээлэл болгон хүргүүлсэн.

³ Харилцагчаас ямар нэг санал ирүүлээгүй болно.

2. ЕСБХБ-ны удирдлагын хариу

Банкны удирдлагын зүгээс үнэлгээний үе шатанд хоёр талт уулзалт хийж, хүсэлтийн талаар байр сууриа илэрхийлсэн. Түүний дараа, илэрхийлсэн санал бодлыг нь ТХБХМ бичгээр нэгтгэн банкны удирдлагад баталгаажуулахаар илгээсэн.

Уг чиглэлийн зам дээр хоёр тусдаа төсөл хэрэгжиж байгаагийн нэг нь АХБ (I үе шат), нөгөө нь ЕСБХБ (II шат)-ны санхүүжилттэй болохыг банкны удирдлагууд онцолж байна. I үе шатанд Улаанбаатар болон Дарханы хоорондох одоо байгаа хоёр урсгалтай замыг шинэчлэх ажил хийгдэнэ. II үе шатанд Улаанбаатараас Дархан хүртэлх 202 км замд хоёр эгнээ нэмж, одоо байгаа хоёр эгнээтэй авто замыг дөрвөн эгнээ болгон өргөтгөх ажил хийгдэх юм. Үүнд эргэлт, тойрог зогсоол зэргийг багтаасан хоёр урсгалтай шинэ зам барих, замын тохижилт (хаалт, гэрэлтүүлэг, явган хүний гарц гэх мэт) хийх, түүнчлэн найман төмөр зам дээгүүр гарам барих, гүүр, ус дамжуулах шугам хоолой барих, засварлах, төлбөр хураах цэгүүдийг шинэчлэх зэрэг ажил орж байна.

ЕСБХБ-ны зээлийн гэрээг 2020 оны 1-р сард байгуулж, барилгын ажлыг 2021 оны 3-р сард эхэлсэн хэмээн тэд мэдээллээ. I үе шатын хүрээнд замын засварын ажлаас үүдэн зам хаасан байсан нь зам хаах шаардлага үүсгээгүй, II үе шаттай хамааралгүй гэж банкны удирдлагууд нэмж мэдэгдэв.

Геологийн онцлогоос шалтгаалж зэрэгцээ барилгын ажил явуулах боломжгүй тул одоо байгаа хоёр эгнээг сэргээн засварлаж дууссаны дараа II үе шатыг эхлүүлэхээр хоёр зээлдүүлэгчид (АХБ ба ЕСБХБ) харилцагчтай тохиролцсон болохыг төслийн баг мэдэгдэв. Энэхүү барилгын ажил дуусмагц, одоогийн байгааг шинэчилсэн хоёр эгнээ зам (I үе шат)-ыг II үе шатны барилгын ажлыг хийхэд түр зам болгон ашиглахаар болсон байна. Хоёр зээлдүүлэгчийн хооронд үүрэг хариуцлага тодорхой хувааж авсан бөгөөд I болон II үе шатын хүрээнд өөрсдийн гэсэн туслан гүйцэтгэгчид авсан боловч үүнийг ерөнхийд нь харилцагч нэгдсэн байдлаар хариуцаж байгаа хэмээн тэд нэмж хэлэв.

Барилга угсралтын ажлын саатал, КОВИД-19-ийн хөл хорио болон бусад хүчин зүйлсийн улмаас 2019 онд дуусгахаар төлөвлөсөн байсан I шатны ажил хойшлогдож, ЕСБХБ-ны санхүүжилтээр хэрэгжих барилга угсралтын ажил эхлэхэд одоо ч дуусаагүй үргэлжилсэн хэвээр байсан.

Үнэлгээний үе шатанд төслийн үйл ажиллагаанд шаардагдах газар нь хязгаарлагдмал түвшний эдийн засгийн дайжилт үүсгэж, барилга байгууламж алдагдуулахад хүргэнэ гэж төслийн багийнхан тооцоолсон байна. Захиалагч нөлөөлөлд өртсөн барилга байгууламжийг нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох журмыг зөвшилцөхийн тулд зам дагуух газарт газар эзэмшигч нартай ярилцаж, хэлэлцсэн.

Зам дагуух газар болон амьжиргааны нөлөөллийг зохицуулахад харилцагчид туслах зорилгоор нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтнүүдээс бүрдсэн мэргэшсэн баг Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө (ГЧНШТ)-г бэлтгэж өгсөн. ГЧНШТ-нд замаас 8 км зайд байрлах хүсэлт гаргагчийн амралтын газрыг багтаагаагүй.

Төслийн баг ЕСБХБ-ны төсөл нь хүсэлт гаргагчийн тавьсан эдийн засгийн хүндрэлтэй шууд холбоогүй гэж үзэж байна. 2020 оны эхэн үеэс Монгол Улсын аялал жуулчлалын салбарт томоохон нөлөө үзүүлсэн КОВИД-19 цар тахлын үеэр тогтоосон хөл хорионы нөлөөнөөс гадна 2019 оноос эхлэн I үе шатны хүрээнд зам хаасан нь гол хүчин зүйл болсон байх магадлалтай

гэж тэд үзэж байна. Дэлхийн банкны мэдээлээс⁴ үзвэл 2019- 2020 оны хооронд тус салбар 90 орчим хувиар уналтад орсон байна. Мөн тэд Монголын аялал жуулчлал нь 2020 оны хоёрдугаар сараас эхлэн хөдөлгөөний хязгаарлалтад орж, саяхан 2022 оны хоёрдугаар сард дахин сэргэсэн олон улсын аялал жуулчлалаас түлхүү хамааралтай хэмээн нэмж дурдав.

Тэд мөн оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ОТОХТ)-нд төслийн гомдлын механизмыг харилцагч бий болгох асуудлыг авч үзсэн гэж тайлбарлав. Цаашилбал, ОТОХТ-нд харилцагч болон гүйцэтгэгч компаниудын холбогдох хэсэгт үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлсон байна.

Нэмж дурдахад, ЕСБХБ болон АХБ хоёулаа орон нутгийн иргэд төслийн талаар мэдээлэлтэй байгаа эсэхийг баталгаажуулж, ОТОХТ-ийн дагуу 2017-2019 онд хэд хэдэн оролцоог хангах үйл ажиллагаа (ярилцлага, судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэг гэх мэт) явуулсан гэдгийг тэд мэдэгдэв. Хүсэлт гаргагчийн байрлаж буй Борнуур суманд 2019 оны 3-р сард Борнуур сумын ИТХ-ын хурал, 2019 оны 2-3-р сард нийт гурван багийн иргэдийн нийтийн хуралд оролцсон талаар дурдлаа. Багийн хуралд оролцогчдын тоог тодорхой заагаагүй байна. Түүнчлэн 2019 оны 3 дугаар сард гомдол гаргагчийн амралтын газарт ойр байрлах Жаргалант суманд мөн адил сумын ИТХ, багийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. ЕСБХБ-ны санхүүжилттэй төслийн байгаль орчин, нийгмийн үнэлгээг боловсруулах ажлын хүрээнд 2019 оны 5 дугаар сард Борнуур, Жаргалант сумдын түвшинд оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагаа зохион байгуулсан байна.

⁴ (Олон улсын аялал жуулчлал, ирсэн хүмүүсийн тоо-Монгол Улсыг үзнэ үү : https://www.google.co.uk/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=&cad=rja&uact=8&ved=2ahUKEwjA_6zEolf6AhVCUMAKHZiGD4kQFnoECCMQAQ&url=https%2FnoECCMQAQ&url=https%2F2ST2Fadt0r.F%2F2AId.INT.ARVL%3Flocations%3DMN&usq=AOvVaw0cE3Lu8V1NI_HPUBStHtU).

3. Комплайнсын үнэлгээний үр дүн

ТХБ-д тогтоосон арга барилыг дагуу кейс нь комплайнсын шалгалтад явуулах шалгуур хангасан эсэхийг тодорхойлохын тулд ТХБХМ нь өмнөх үе шатанд цуглуулсан баримт бичиг, мэдээлэл, 2022 оны 9-р сараас эхлэн энэхүү комплайнсын үнэлгээний тайланг боловсруулж дуустал цуглуулсан төслийн бусад мэдээлэл болон нийтэд нээлттэй мэдээллийг харгалзан кейс 2022/01-д⁵ үнэлгээ хийсэн.

Энэхүү үнэлгээний зорилго нь комплайнсын шалгалт руу үргэлжлүүлэх эсэхийг тодорхойлоход оршиж байгаа тул дүгнэлт нь зөвхөн ТХБ-д заасан шалгуурыг хангасан эсэхийг тодорхойлох чиглэгдсэн урьдчилсан шинж чанартай юм. Үүнийг ЕСБХБ-ны 2014 оны Байгаль орчин, нийгмийн бодлого болон Мэдээллийн хүртээмжийн бодлогын төсөлтэй холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг ТХБХМ-аас дүгнэж тогтоосон гэж үзэж болохгүй юм.

Хүсэлт гаргагч нь Улаанбаатар-Дархан чиглэлийн замыг 2019 оны зун хааж, 2022 оныг дуустал энэ хэвээр үргэлжилсэн хэмээн мэдэгдсэн.⁶ Түүний хэлснээр, энэ нь амралтын газрын захиалгад шууд нөлөөлсөн бөгөөд амралтын газар руу очих боломжгүй байсан тул захиалгаа шууд цуцалсан байна.

Төслийн олон нийтэд нээлттэй болгосон баримт бичигт, “2017 онд Засгийн газраас Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг шинэчлэх ТЭЗҮ-г захиалж; 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Засгийн газрын шийдвэр гарсан. Санал болгож буй ажлуудыг хоёр үе шатанд хуваасан: I үе шат - одоо байгаа замыг шинэчлэх; болон II үе шат - цаашид нэмж 2 эгнээтэй зам барих өргөтгөл.

I үе шат нь АХБ-ны санхүүжилтээр хийгдэж байгаа бөгөөд 2 эгнээтэй замыг сэргээн засварлах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах ажлыг хамарч байна. 2019 оны 4-р сарын сүүлээр I үе шатны төслийн барилгын тендерийн зар гарсан бөгөөд барилгын ажлыг 2019 оны зун эхлүүлэхээр төлөвлөж байсан.

II үе шатны ажилд ЕСБХБ-аас санхүүжилт олгохоор төлөвлөж байгаа бөгөөд үүнд замыг 4 эгнээтэй хурдны зам болгох ажил хамарч байна. 2019 оны намраас 2020 оны зун хүртэл ажил хийгдэнэ гэж таамаглаж [байсан]⁷, хэмээжээ.

Төсөл нь Улаанбаатар хотын захад Дархан-Эмээлтийн уулзвараас эхэлж, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21 болон 32-р хорооны нутгаас цааш гурван аймаг⁸ болон зургаан сумын⁹ нутгаар дайран өнгөрдөг, үүнд: Төв аймгийн Баянчандмань, Борнуур сум, Сэлэнгэ аймгийн Баянгол, Мангал сум, Дархан-Уул аймгийн Хонгор сум болоод Дархан хотын өмнөд хэсэг (замын төгсгөл).

⁵ <https://www.ebrd.com/work-with-us/projects/ipam/2022/01.html>.

⁶ Харилцагч 2022 оны 7-р сард ТХБХМ-ын айлчлалын үеэр 2019 оны зунаас эхлэн замыг хаасан бөгөөд Улаанбаатар хотоос амралтын газар байрлах хэсэг хүртэлх замыг 2 багцад хувааснаас 1-р багцыг аль хэдийн хийж дуусгасан болохоо баталгаажуулсан. Гэсэн хэдий ч 2-р багц хэд хэдэн сааталтай тулгарсан тул замын хөдөлгөөнийг түр замаар явуулж буй хэвээр байсан.

⁷ Техникийн бус хураангуй (ТБХ), хуудас 6, <https://www.ebrd.com/work-with-us/projects/esia/ulaanbaatar-darkhan-road-project.html>.

⁸ Аймаг нь засаг захиргааны нэгдүгээр шатлалын нэгж юм.

⁹ Сум нь аймгийн дор орших засаг захиргааны хоёрдугаар шатлалын нэгж юм.

Төслийг доорх хүснэгтэд тайлбарласны дагуу таван хэсэг буюу "багц"-т хуваасан:

Төслийн хэсгүүд

Хэсэг буюу Багц	Ерөнхий мэдээлэл	Урт (м)	Төслийн эхлэх цэг - метрээр	Төслийн дуусах урт - метрээр	Эхлэх цэгээс км-р	Төгсөх цэг км-р
I	Дархан-Эмээлтийн уулзвараас эхлэн Хар модотын давааны хойд талд (52-р зөрлөг)	37,281.77	0	37,281.77	18.9	56.18
II	Хар модот давааны хойд талаас Тайсын давааны урд	45,500.17	37,281.77	82,781.94	56.18	101.68
III	Урихан хоолны газар хавьцаагаас төв аймгийн Сүмбэр сум буюу Бор толгойн замын уулзвар хүртэлх	45,753.06	82,781.94	128,535.00	101.68	147.44
IV	Төв аймгийн Сүмбэр сумын Бор толгойн замын уулзвараас Цайдам хөндий хүртэлх	45,050.56	128,535.0 0	173,585.56	147.44	192.49
V	Цайдамын хөндийгөөс Дарханы уулзвар хүртэл	28,840.00	173,585.5 6	202,425.56	192.49	221.33

Эх сурвалж: МСРС (2019 оны 5-р сарын 21), Инженерийн тайлбарын тайлан – 1-р хэсэг.

ТХБХМ нь дараахыг тогтоохоос үүднээс төслийн баримт бичгийг урьдчилсан байдлаар хянан үзэж, хүсэлт гаргагч, удирдлага, харилцагчтай хамтран ажиллав. Үүнд

- Урьдчилсан байдлаар авч үзэхэд төслүүд нь хүсэлт гаргагчид (эсвэл, өөр бол Төслийн нөлөөлөлд өртсөн холбогдох хүмүүст) шууд болон шууд бус болон материаллаг хохирол учруулсан буюу учруулах магадлалтай гэж харагдах; мөн
- Банк нь Байгаль орчин, нийгмийн бодлогын заалтууд (үүнд Банкнаас харилцагчийн хүлээсэн амлалтад хяналт тавихыг шаардсан заалтыг оруулаад); эсвэл уг төсөл батлагдах үед мөрдөгдөж байсан Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)-ын төсөлтэй холбоотой заалтуудыг дага мөрдөөгүй байж болзошгүй.

Дараах хэсгүүдэд хийсэн дүн шинжилгээ, дүгнэлтийг харуулав.

3.1 Улаанбаатар-Дарханы зам төсөлтэй холбоотой учирч болзошгүй хор хохирлын талаар

2019 оны зун замын засварын ажилд зориулж замын хэсгийг хааснаар эдийн засгийн дайжилтын асуудал эхэлсэн бөгөөд орлох замуудын нөхцөл байдал муу байгаагаас олон тооны осол гарсан гэж хүсэлт гаргагч мэдэгдэв. Хүсэлт гаргагчийн хэлснээр, зам хаагдсан үед зочид хаагдсан үед захиалгаа цуцалж, буцаж ирээгүйгээс үүдэн амралтын газрын орлогод сөргөөр нөлөөлж, улмаар амралтын газрын тайлан баланс болон түүнээс амьжиргаа нь хамааралтай айл өрхүүдэд нөлөөлсөн байна.

Замыг 2019 оны наймдугаар сард буюу аялал жуулчлалын идэвх өндөр зуны улирал дуусах хавьцаа хааж, ТХБХМ-ын олж мэдсэнээр 2022 оны 10-р сарыг дуустал хаалттай хэвээр байжээ.¹⁰ Үүн дээр нэмээд Ковид-19-тэй холбоотой хөл хорио 2020 оны 3-р сараас тавигдаж

¹⁰Замыг 2022 оны 10-р сард дахин нээсэн талаар ТХБХМ-д саяхан мэдэгдсэн.

эхэлсэн, 2021 оны эцсээр (олон улсын аялал жуулчлалын хувьд), 2022 оны хоёрдугаар сарын 1411 (онцгой байдлын хувьд) хөл хорио цуцлагдаж эхэлсэн. 2022 оны 7-р сард ТХБХМ-ын Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр хүсэлт гаргагч нь ковидтой дотоодын хөл хориог цуцалсан хэдий ч захиалга зам хаахаас өмнөх түвшиндээ буцаж ирээгүй гэж хэмээн тайлбарлав.

Комплайнсын үнэлгээний үе шатанд ТХБХМ нь хүсэлт гаргагчтай нэмэлт ярилцлага хийж, захидал, видео материал, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд цацагдсан нэмэлт материалыг хянаж үзсэн. Үүнтэй зэрэгцэн тус амралтын газрын 2018-2021 оны татварын тайланг мөн хянаж үзсэн.¹²

Татварын тайлангаас харахад бизнесийн орлого 2020 онд өмнөх онтой харьцуулахад ойролцоогоор 75%-иар буурч, 2021 онд төдийлөн өөрчлөлт ороогүй байна.¹³

Бизнесийн үйл ажиллагаа буурсан нь татварын тайлангаас харагдаж байна. ТХБХМ нь КОВИД-19-ийн нөлөөнөөс гадна зам хаасан нь нөлөөлсөн хүчин зүйл байж магадгүй гэж үзэж байна. ТХБХМ нь зам ашиглах боломжгүй болсон гэж буй нь бизнесийн идэвхжил буурахад хэр зэрэг нөлөөлсөн болохыг одоогийн байдлаар тодорхойлох боломжгүй байгаа тул шалгалтын явцад цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.

Хүсэлт гаргагчийн мэдээлснээр амралтын газар ихэнх ажилчдаа халсан (ТХБХМ-д өмнө нь 20 (өвлийн улиралд) 34 (зун) ажилчин ажилладаг байсан гэж мэдээлсэн). Нэмж дурдахад, хүсэлт гаргагч зам хаагдсанаас болж үл хөдлөх хөрөнгийн үнэ маш их буурч, амралтын газраа зарж чадахгүй болсон тухайгаа дурджээ.

Ковидийн дараах нөлөөллийн хувьд, 2022 оны 6-р сарын сүүлээр ажилтнуудаа амраахаар захиалга хийж, урьдчилгаа төлсөн боловч захиалгаа цуцлахаар шийдсэн томоохон компанийн 2022 оны 6-р сарын 6-ны өдрийн захидлыг ТХБХМ үзсэн. Тус компанийн төлөөлөгч албан бичигтээ “Дарханы авто замын шинэчлэлтийн ажилтай холбоотой бааз руу явах, буцах үед ажилчдын аюулгүй байдалд эрсдэлтэй” зэрэг шалтгаанаар захиалгаа цуцлах хүсэлтэй байгаагаа мэдэгдэж, урьдчилгаа төлбөрөө буцааж өгөхийг хүссэн байна.

Аюулгүй байдлын асуудлын талаар хэд хэдэн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж, хүний амь нас хохирсон зам тээврийн ослын тоо, түр замуудын нөхцөл байдлын талаар олон нийт санаа зовниж буйг онцолсон байна. Үүнтэй холбогдуулан Дарханы замын хохирогчдын гаргасан нэхэмжлэлийн дагуу “Дархан-УБ авто замын засварын ажил удааширснаас олон иргэн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөөрөө хохирсон” гэх мэдээлэл цацагдсан. Нэг нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлдээ, “200 гаруй хохирогч бүртгэгдсэн [одоогийн байдлаар]” гэх мэдээллийг ишилжээ.¹⁴ Түүнчлэн Үндэсний аудитын газраас уг төсөлд

¹¹<https://stonehorsemongolia.com/mongolia-covid-19-information>. Хамгийн сүүлд 2023 оны 1-р сарын 17-нд хандсан.

¹²<https://nema.gov.mn/wp-content/uploads/2022/02/Doc2-1.pdf>. Хамгийн сүүлд 2023 оны 1-р сарын 17-нд хандсан.

¹³ Татварын тайлан нь монгол хэл дээр байсан тул англи хэл рүү хөрвүүлсэн.

¹⁴ 2019 онд ашиг нь аль хэдийн мэдэгдэхүйц буурсан байсан бол 2020 онд орлого нь эрс буурсан (жилээс жилд харьцуулахад) байгаа харагдаж байна. Урьдчилан мэдэгдэлгүйгээр зам хааснаар 2019 оны 8-р сараас эхлэн орлого огцом буурсан гэж хүсэлт гаргагч үзэж байна. Жилээр гаргасан тайлангийн онцлогоос шалтгаалж тодорхой үнэлэхэд хэцүү ч цар тахлын өмнөх 2019 оны санхүүгийн жилд ашиг мэдэгдэхүйц буурсан байсныг ТХБХМ тэмдэглэж байна.

¹⁴¹⁴ Иргэний хэргийн шүүх хурал 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд болсон болохыг ТХБХМ-аас мэдээний бичлэгээс олж үзсэн. Нэхэмжлэгч нь Дарханы дутуу барьсан замд чиргүүлийн дугуй нь дөрвөн удаа буудаж, тус зам дээр эд хөрөнгийн хохирол учирсан гэх

хяналт, шалгалт хийж, замын нөхцөл байдал муу байгааг нотолсон” гэх мэдээлэл гарсан байна.¹⁵

Дүгнэж хэлэхэд, хүсэлт гаргагчийн тавьсан зорчих хугацаа нэмэгдсэн болон аюулгүй байдлын асуудлууд нь ерөнхийдөө хүмүүсийн санаа зовнисон асуудал болсон байна. Түүгээр ч зогсохгүй, түр замуудын нөхцөл байдал, осол аваарын тоо зэрэг нь зорчих сонирхлыг бууруулсан бололтой.¹⁶

Энэ бүх материалыг өмнө нь цуглуулсан нотлох баримтууд, тэр дундаа газар дээр нь очиж үзэх явцад цуглуулсан мэдээлэлтэй¹⁷ хамтад нь авч үзэхэд хүсэлт гаргагчийн гаргасан мэдэгдэлтэй таарч буй буюу зам засвар, өргөтгөлийн ажил нь эдийн засгийн дайжилтад ямар нэгэн байдлаар хувь нэмрээ оруулж болохуйц тодорхой сөрөг нөлөөллийг үүсгэж буй мэт мэт харагдаж байна.

Гэсэн хэдий ч ЕСБХБ-ны удирдлагаас ЕСБХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл буюу төслийн II шат нь хүсэлт гаргагчийн дэвшүүлсэн асуудлыг үүсгээгүй хэмээн мэдэгдэхийн зэрэгцээ хэрэв ямар нэгэн байдлаар төсөл тухайн асуудлуудтай холбоотой гэж үзэх бол ЕСБХБ-ны санхүүжилттэй төслийн хүрээнд бодит бүтээн байгуулалтын ажил **2021 оны гуравдугаар сард** эхэлсэн тул I үе шат (АХБ-ны санхүүжилттэй бүрэлдэхүүн хэсэг)-аар хязгаарлагдана гэх нэмэлт тайлбарыг өгөв. Цаашилбал, ЕСБХБ-ны санхүүжилттэй төслийн хамрах хүрээ нь одоогийн Улаанбаатар-Дарханы зам (УБ-Дарханы зам)-д **хоёр шинэ эгнээ барих өргөтгөлийн ажлыг** хамрах болохоос одоогийн УБ-Дарханы замын “засварлах” ажилтай холбоогүй хэмээн онцлов.

Удирдлагын гаргасан үндэслэлийг ойлгож, I үе шатны шатны үйл ажиллагаа 2019 онд эхэлсэн, II үе шатны үйл ажиллагаа хожим нь эхэлсэн гэсэн тэдний мэдэгдлийг хүлээн зөвшөөрч, ТХБХМ нь ЕСБХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл нь “хүсэлт гаргагчид шууд болон шууд бус материаллаг хохирол учруулсан эсвэл учруулж болзошгүй” эсэхийг тогтоохын тулд БОНБ-ын бодлогын шаардлагыг харгалзан үзэх шаардлагатай.

ТХБХМ-ын зүгээс үнэлж үзэхэд, уг төсөл нь анхандаа 2017 онд “Монголын Барилгын Төслийн Зөвлөхүүд Групп” ХХК-ийн боловсруулсан нэг ТЭЗҮ-тэй нэг төсөл байсан болохыг харуулж байна. Тэрхүү ТЭЗҮ-д техник, нийгэм эдийн засаг, байгаль орчны шинжилгээнд үндэслэн замын нөхөн сэргээж засахаас гадна одоогийн 2 эгнээг 4 эгнээ болгон өргөтгөхийг зөвлөсөн байна. Төслийг

үндэслэлээр Зам тээврийн яамыг шүүхэд өгсөн иргэн юм. Нэхэмжлэгчийн хууль ёсны төлөөлөгч, “Дарханы замын замын нөхцөл улмаас гэмтэж бэртсэн, эд хөрөнгийн хохирол учирсан, /эсвэл амьт насан алдсан (40 гаруй кейс) 200 гаруй тохиолдол бий” тул энэ нэг хүний кейс биш гэдгийг онцолсон байна. Мөн тэрээр “Дарханы замын нөхцөл байдал муу байгаа нь ослын нэг гол шалтгаан болж байгааг ард түмэн анхаарах хэрэгтэй” гэдгийг тодотгосон байна. Хамгийн сүүлд 2023 оны 1-р сарын 17-нд хандсан доорх холбоосыг харна уу:

- [Дарханы замд хохирсон иргэний шүүх хурал 11-р сар хүртэл хойшиллоо | #C1NEWS Дарханы замд хохирсон иргэний шүүх хурал 11-р сар хүртэл хойшиллоо #C1TELEVISION | By C1 NEWS | Facebook](#)
- [Дарханы замд хохирсон иргэдийн шүүх хурал хойшиллоо](#)

¹⁵Эдгээр бүх асуудлыг ТХБХМ-аас газар дээр нь очиж үзэх үеэр цуглуулсан нотлох баримтууд нотолж байгаа, зүүлт тайлбар 16-г үзнэ үү.

¹⁶Зам, тээврийн хөгжлийн яаманд хандан 2021 оны 7-р сард илгээсэн захидлын орчуулгыг ТХБХМ үзсэн бөгөөд үүнд хүсэлт гаргагчид өөрсдөө “замын дээд хучилтыг хуулж авсны улмаас олон тооны зам тээврийн осол гарч байгаа” болон бусад асуудлыг хөндсөн байна.

¹⁷ТХБХМ-ын баг Улаанбаатар хотоос амралтын газар руу зорчиход гурван цаг зарцуулдаг, түр замуудын нөхцөл байдал туйлын муу, замын тэмдэг, тэмдэглэгээ байхгүй болохыг баталжээ. Мөн шороон замын нөхцөл байдал маш муу, тэмдэг тэмдэглэгээ байхгүй, автомашинууд бэлчээрийн талбайг дайран өнгөрч буйг ТХБХМ-ын багийнхан онцолжээ. Эцэст нь, ТХБХМ нь хэд хэдэн осол гарсан, эдгээр осол болон төслөөс үүдэлтэй бусад төлөөлөгчид болж оршин суугчид болон аялагчдаас гомдол гаргасан талаар тухай янз бүрийн оролцогч талуудаас сонссон байна.

яагаад хоёр үе шаттай болгож хуваасан бөгөөд ТХБХМ-ын урьдчилсан үнэлгээгээр уг хоёр байгууллага (ЕСБХБ болон АХБ) хамтран ажилласан эсэх, мөн ЕСБХБ нь үе шат I-ийг өөрийн эрсдэлийн үнэлгээндээ харгалзан үзсэн эсэх нь тодорхойгүй байна.

Дагалдах БОННУ-нд, “энэ төсөл [ЕСБХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй II үе шат]-ийн үндсэн холбогдох байгууламж нь одоо байгаа 2 эгнээтэй замыг сэргээн засварлах, түүний дотор эдгээр I үе шатны ажилд шаардагдах түр замуудыг гаргах ажлыг хамрах АХБ-ны I шатны төсөл юм” хэмээн тусгажээ.¹⁸

2014 оны БОНБ (30-р хэсэг)-д, “ЕСБХБ-ны байгаль орчин, нийгмийн үнэлгээ нь гурван үндсэн элементийг авч үзнэ, үүнд: (i) байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, төсөлтэй холбоотой асуудлууд; (ii) ГШ-ын дагуу төслийг хэрэгжүүлэх харилцагчийн чадавхи, үүрэг амлалт; ба (iii) хамааралтай зохих түвшинд, **төсөлтэй холбоотой боловч ЕСБХБ-аас санхүүжүүлээгүй байгууламжууд**” гэж заасан, мөн (Гүйцэтгэлийн шаардлагын тухай 37-р хэсэг)-т, “**түүнчлэн ЕСБХБ нь төсөлтэй холбоотой боловч төслийн нэг хэсэг биш үйл ажиллагааг байгаль орчин, нийгмийн эрсдэлийг ГШ-д нийцүүлэн удирдахын тулд харилцагчидтайгаа хамтран ажиллана**” гэж, эцэст нь (ГШ 1.9)-д, “байгаль орчин, нийгмийн үнэлгээний үйл явц нь **төслийн нэг хэсэг биш боловч зөвхөн төслөөс болж оршин буй эсхүл төсөлд эрсдэл учруулж болзошгүй, төслөөс шууд болон шууд бусаар нөлөөлж болох үйл ажиллагаа, байгууламжтай холбоотой байгаль орчин, нийгмийн чухал ач холбогдолтой асуудлуудыг зохих хэмжээгээр тодорхойлж, тусгахад чиглэгдэнэ. Эдгээр холбогдох үйл ажиллагаа, байгууламжууд нь төслийн хэрэгжих боломжид чухал ач холбогдолтой байж болох бөгөөд харилцагчийн хяналт дор эсвэл гуравдагч этгээдийн ашиглалт эсвэл харьяалалд байж болно**” хэмээн тус тус тусгасан байдаг.¹⁹

Банк үүний дагуу I ба II үе шатыг магадлан судалгаа болон үнэлгээний үе шатанд хамтад нь авч үзсэнийг батлах хэд хэдэн тохиолдол төслийн баримт бичигт тусгагдсан байна.

- Харилцагч болон зээлдүүлэгчид оролцогч талуудын оролцоог хангах асуудлын хүрээнд төслийг нэг бүхэл гэж тодорхойлсон.
- ГЧНШХ-нд Төслийн I, II үе шатуудад нөлөөлөлд өртсөн хүмүүсийг “нэгэн зэрэг тодорхойлсон” хэмээн тусгаан.²⁰
- Оролцогч талуудын оролцоог хангах зарим эхний ажлуудыг үе шат бүрд тусад нь явуулсан боловч ЕСБХБ-нд хараат бус зөвлөхийн бэлтгэж өгсөн ОТОХТ-нд ЕСБХБ-ны санхүүжилтээр хийх ажлуудыг “нэг зам дээр хийхээр төлөвлөж байгаа” тул I болон II үе шатыг хоёуланг нь авч үзсэн байна.²¹
- Төслийн АХБ болон ЕСБХБ-ны үе шатуудыг дараах байдлаар өргөн хүрээнд зэрэг боловсруулж, шат дараатай хэрэгжүүлнэ хэмээн ойлгож байна.
 - 1-р үе шат – одоо байгаа авто замын дэд бүтцийг сэргээн засварлах/сайжруулах (АХБ-наас санхүүжүүлэх); мөн

¹⁸IPPF SIW - Mongolia: Улаанбаатар-Дархан авто замын Байгаль орчин, нийгмийн үнэлгээ (БОНУ), Нэмэлт баримт бичиг: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ), SNC Lavalin, 2019 оны 7-р сар, хуудас 15.

¹⁹БОННУ, 15-р хуудас.

²⁰ГЧНШХ эцсийн хувилбар, 63-р хуудсыг үзнэ үү <https://www.ebrd.com/work-with-us/projects/esia/ulaanbaatar-darkhan-road-project.html>

²¹ОТОХТ эцсийн хувилбар, хэсгийн 4.1, хуудас 20-г үзнэ үү <https://www.ebrd.com/work-with-us/projects/esia/ulaanbaatar-darkhan-road-project.html>

- 2-р үе шат – хоёр эгнээ зорчих хэсэгтэй болгохын тулд замыг өргөтгөх (ЕСБХБ-аас санхүүжүүлэх).

АХБ-ны төслийн ажил түрүүлж эхлэх боловч ЕСБХБ-ны гэрээ байгуулсны дараа ажил нэгэн зэрэг хийгдэнэ.²²

- Магадлан судалгааны баримт бичигт өргөдөл гомдлын давхардал эсхүл ойлгомжгүй байдлаас зайлсхийхийн тулд I болон II үе шатыг хоёуланг нь хамарсан иргэдийн гомдол барагдуулах нэгдсэн механизмыг хэрэгжүүлэх; мөн гомдол барагдуулах нэгдсэн арга барил, бүртгэлтэй ажиллахыг баталгаажуулна.²³
- “ТХН, ЗТХЯ, ЕСБХБ, АХБ болон барилга угсралтын гүйцэтгэгч компаниуд хооронд төсөлтэй холбоотой ерөнхий асуудлаар үр дүнтэй харилцдаг байх, мөн эдгээр түншүүдэд төслийн байдал, үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлэл солилцож байх” зөвлөмжийг ОТОХТ-нд тусгайлан зааж оруулсан байгаа нь бүрэлдэхүүн хэсэг бүр нь тусдаа орчинд хэрэгжихгүй тул тусад нь задлан шинжлэх боломжгүй, бодит байдал дээр өргөн хүрээтэй нэг төслийн болохыг хүлээн зөвшөөрсөн байна.

Комплайнсын үнэлгээний үе шатанд ТХБХМ нь зээлдүүлэгчдийн хоорондын захидал харилцаа зэрэг зарим дотоод баримт бичгүүдэд урьдчилсан шалгалт хийх боломжтой болсон. Зээлдүүлэгчдийн хооронд 2019 оны 7-р сарын и-мэйд "АХБ болон ЕСБХБ-ны төслүүд нь үндсэндээ нэг төслийн ондоо хэсэг" гэх үндэслэлээр санал болгож буй арга барилыг зохистой гэж үзсэн байна.

ТХБХМ нь дээр дурдсан үндэслэн төсөл нь хүсэлт гаргагчид шууд болон шууд бус хохирол учруулсан байж болзошгүй хэмээн урьдчилсан байдлаар үзэж байна. Иймд ТХБ-ын 2.6 (b)-д заасан хүсэлтэд комплайнсын шалгалт хийхэд тавигдах шалгуурын нэг хангагдаж байна.

3.2 Эдийн засгийн дайжилтын тухайд

Хүсэлт гаргагч нь өөрийн амралтын газарт очих замыг удаан хугацаагаар хаасан, түр замын нөхцөл муу байгаагаас үүдэн эдийн засгийн дайжилт үүссэн хэмээн гомдол гаргажээ. Тэрээр хүсэлтдээ тус амралтын газар захиалга эрс багассаны улмаас орлого нь буурч, зарим ажилчдаа ажлаас нь халж, эд хөрөнгөө зарж, дампуурлаа зарлахаар бодоход хүрсэн хэмжээн тайлбарласан байна.

ТХБХМ-аас төслийн баримт бичигт хийсэн урьдчилсан шалгалт нь банк чөлөөтэй явах боломжтой байх асуудлыг хэрхэн авч үзсэнийг олж тогтооход чиглэв. Үүний хүрээнд эхлээд төслийн байгаль орчин, нийгмийн ул мөр ямар байсан, банк эдийн засгийн дайжилт (түр эсвэл байнгын)-ыг болзошгүй нөлөөллийн нэг гэж тодорхойлж, улмаар үнэлгээний үе шатанд түүнийг бууруулах арга хэмжээ авч үзсэн эсэхийг тогтоох шаардлагатай болсон.

БОННУ-г шалгаж үзэхэд, тодорхойлсон төслийн нөлөөллийн бүсэд тус амралтын газрыг оруулаагүй, мөн нийтэд ил болгосон төслийн баримт бичигт түр зам, тэдгээртэй холбоотой тодорхой техникийн шаардлагыг тусгасан хэдий ч тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа

²²ТХБХМ-аас хянасан дотоод баримт бичгийн дагуу.

²³ ГЧНШХ эцсийн хувилбар, 74-р хуудсыг үзнэ үү <https://www.ebrd.com/work-with-us/projects/esia/ulaanbaatar-darkhan-road-project.html>.

явуулахын тулд зам ашиглаж байгаа аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг тусгаагүй байгааг ТХБХМ тогтоосон.

Банкны удирдлага нь I үе шатны хүрээнд 2019 оноос эхлэн зам хаасан нь хүсэлт гаргагчийн хөндсөн асуудлуудад нөлөөлөх хүчин зүйлүүдийн нэг байсан байж магадгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн, мөн түүнчлэн КОВИД-19 цар тахалтай холбоотой зорчих хөдөлгөөний хориг нь 2020 оны эхнээс аялал жуулчлалын салбарт их хэмжээний сөрөг нөлөө үзүүлсэн гэж мэдэгдсэн. Түүнчлэн, I үе шатны ажлыг 2019 онд дуусгааар төлөвлөсөн байсан ч олон удаа хойшлогдсоор ЕСБХБ-ны санхүүжилтээр хийгдэх ажлууд эхлэх үед дуусаагүй байсныг хүлээн зөвшөөрсөн. Гэсэн хэдий ч, ингэж хойшлоход банк ямар хариу үйлдэл үзүүлсэн, ямар нэг арга хэмжээ авсан эсэх талаар ямар нэгэн тайлбар хийгээгүй байна.

I үе шатыг төслийн холбогдох байгууламж гэж үзвэл, 2014 оны БОНБ-д А ангиллын төсөлд хийх "байгаль орчин, нийгмийн үнэлгээний үйл явц нь төслийн нэг хэсэг биш боловч зөвхөн төслөөс болж оршин буй эсхүл төсөлд эрсдэл учруулж болзошгүй, төслөөс шууд болон шууд бусаар нөлөөлж болох үйл ажиллагаа, байгууламжтай холбоотой байгаль орчин, нийгмийн чухал ач холбогдолтой асуудлуудыг зохих хэмжээгээр тодорхойлж, тусгахад чиглэгдэнэ" хэмээн заасан байна.

ТХБХМ нь одоогийн байдлаар тодорхой дүгнэлтэд хүрэх боломжгүй байгаа боловч урьдчилсан дүгнэлтээс харахад банк төслийг үнэлэх явцдаа I үе шаттай холбоотой байгаль орчны ба/эсвэл нийгмийн асуудлыг авч үзсэн эсэх, мөн тийнхүү авч үзээгүй ч гэсэн хийгдэх ажил хойшлогдож, төв зам урт хугацаагаар хаагдах болсныг мэдмэгцээ дараа нь ямар нэгэн үнэлгээ хийсэн эсэхийг шалгах нь зүйтэй байна.

2014 оны БОНБ болон олон улсын сайн туршлагад эдийн засгийн түр зуурын дайжилтын асуудлууд болон түүнээс үүдэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлохыг заасан заалтуудыг байдаг.

Үүнтэй холбогдуулан ЕСБХБ нь 2014 оны БОНБ-оо мөрдсөн эсэхийг тогтооход тавигдах гол асуудал нь төслийн дотоод үнэлгээний явцад төсөл болон түүнтэй холбоотой байгууламж/үйл ажиллагаанаас үүсэх шууд болон шууд бус нөлөөллийг үнэлэх зорилгоор төслийн нөлөөллийн бүсийг хэрхэн тодорхойлсон, чөлөөтэй нэвтрэхэд хязгаарлалт байгаа эсэхийг авч үзсэн эсэх асуудал юм.

3.3 Байгаль орчин, нийгмийн асуудалд хийгдэж буй менежмент, мониторингийн талаар

Хүсэлтэд дурдсан асуудлуудыг олон талаас харах шаардлагатай бөгөөд тэдгээрээс ГШ1-д давхар хамааралтай нэг нь төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн асуудалд мониторинг хийж, удирдах явдал юм.

Төслийн мониторинг нь урьдчилан тооцоолоогүй нөлөөллийг илрүүлж, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэхийг тодорхойлох нь олон улсын сайн туршлага юм²⁴.

²⁴ 2014 оны БОНБ-д, "олон улсын болон бүс нутгийн хэмжээнд ижил эсхүл төстэй нөхцөл бүхий үйл ажиллагаанд үр чадвар, туршлагатай мэргэжилтнүүдийн авч хэрэгжүүлэх мэргэжлийн үр чадвар, судалгаа, няхуур байдал, сахилга, няхуур болон тооцооллыг хэрэглэнэ. Уг ажлын үр дүн нь төсөлтэй холбоотой онцгой нөхцөл хамгийн зохистой технологийг төсөлд хэрэгжүүлнэ" хэмээн олон улсын сайн туршлагыг тодорхойлсон байна.

Замыг хаах болон түүнтэй холбоотой асуудлууд (зам тээврийн осол гэх мэт) нь хамгийн багадаа гурван жилийн хугацааг хамарч буй нь хүсэлт гаргагчийн бизнест "алдагдсан" зуны гурван улиралтай тэнцэж байна (ТХБХМ-д байгаа мэдээллээс үзэхэд замыг эхлээд 2022 оны 8-р сарын дундаас 10-р сар хүртэл хаасан байна).

2014 оны БОНБ-ын ГШ1-ийн 29-р заалт болон бусад холбогдох заалтад заасны дагуу "харилцагч нь ЕСБХБ-нд дараах асуудлыг нэн даруй мэдэгдэх ёстой, үүнд (i) харилцагч эсвэл төсөлтэй холбоотой байгаль орчны болон нийгмийн аливаа аваар, осол, мөн (ii) байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, асуудлыг бодитоор өөрчлөх боломжтой төслийн цар хүрээ, дизайн, үйл ажиллагаанд гарсан аливаа өөрчлөлт тус тус хамаарна. Удаан хугацааны турш замыг хаасан нь төсөлтэй холбоотой гол байгууламжийн үйл ажиллагаанд ихээхэн өөрчлөлт оруулсан бөгөөд 2-р үе шатанд ч чухал нөлөө үзүүлж болзошгүй юм. Ийм нөхцөлд, "харилцагч нь ГШ-д заасны дагуу шаардлагатай аливаа нэмэлт үнэлгээг хийж, оролцогч талуудын оролцоог хангаж, гарсан үр дүнд тулгуурлан ЕСБХБ-тай тохиролцсоны дагуу БОНМТ эсвэл БОНУАТ-нд нэмэлт, өөрчлөлт оруулах юм".

Дээр дурдсанчлан, 2014 оны БОНБ-ын 37-р заалт (Гүйцэтгэлийн шаардлагууд)-ад, "ЕСБХБ нь төслийн нэг хэсэг биш боловч түүнтэй холбогдох үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн эрсдэлийг ГШ-д заасны дагуу удирдахын тулд харилцагчидтайгаа хамтран ажиллана" гэж заасан.

Иймээс төсөл болон түүнтэй холбогдох байгууламжид мониторинг хийхтэй холбоотой гол асуудал нь I үе шаттай холбоотой хийгдэж буй асуудлуудын талаар ЕСБХБ-д мэдээлэл өгсөн эсэх, тийм бол хэзээ өгсөн, мөн эдгээр асуудлаас үүдэлтэй газар дээр дээр үүссэн нөхцөл байдал, хор хохирлыг арилгах, эцсийн дүндээ төслийн техник эдийн засгийн үндэслэл, тогтвортой байдлыг бүхэлд нь хадгалахын тулд тус банк ямар арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн мөн/эсхүл харилцагчаас авч хэрэгжүүлэхийг хүссэн болохыг тогтоох шаардлагатай.

Одоогоор ТХБХМ-д энэ асуудлыг зохистой үнэлэх бүх мэдээлэл байхгүй бөгөөд комплайнсын шалгалтын хүрээнд зам хаагдсан, осол гарсан асуудалтай холбогдуулан ЕСБХБ-аас дангаараа эсвэл АХБ-тай зөвшилцсөний үндсэн дээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, болсон үйл явдлын дарааллыг зөв тогтоож, сайтар дүн шинжилгээ хийж, үүнийг тогтоох нь чухал гэж үзэж байна.

3.4 Оролцогч талуудын оролцоог хангах талаар

Хүсэлт гаргагч нь зөвлөгөөнд хамрагдаагүй, зам хаах талаар мэдээлэл аваагүй гэж тайлбарласан.

2014 оны БОНБ-ын 34-р заалтад, "ЕСБХБ-ны төслийн дотоод үнэлгээний хүрээнд төсөлд өртөж болзошгүй болон/эсвэл төслүүдийг сонирхож болзошгүй оролцогч талуудыг тодорхойлж, төслөөс үүсэх нөлөөлөл, асуудлын талаар хангалттай мэдээллийг ил болгож, оролцогч талуудтай үр дүнтэй, соёлын онцлогт тохирсон зөвлөлдөхийг зөвшилцөхийг харилцагчдаас шаардана. Ялангуяа, ЕСБХБ нь харилцагчдаасаа төсөлтэй холбоотой учирч болзошгүй нөлөөлөл болон санаа зовоосон асуудалтай нь уялдуулан холбогдох оролцогч талуудтай харилцахыг шаардана" хэмээн заажээ. Цаашилбал, ГШ1 нь А ангиллын төслүүдийн БОННУ хийх явцад нь ГШ10-д заасны дагуу олон нийтэд мэдээлэх, зөвлөлдөх үйл явцыг багтаасан байх шаардлагатай.

Магадлан судалгаа хийх явцад зөвлөхүүд нь оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагаа нь үндэсний стандартад нийцэж байгаа хэдий ч ЕСБХБ-ны шаардлагыг хангахад хэд хэдэн дутагдал байгааг олж тодорхойлсон байна. Тиймээс оролцогч талуудын жагсаалтыг ОТОХТ-д

оруулсан бөгөөд үүнийг тогтмол хянаж, шинэчилж байх ёстой. Энэхүү жагсаалтад төслийн нөлөөллийн бүсэд орлого, ажлын байраа алдаж болзошгүй орон нутгийн бизнес эрхлэгчид болон барилга угсралтын ажлын явцад одоо байгаа замыг ашиглахад хөдөлгөөний хязгаарлалттай тулгарч болзошгүй авто зам ашиглагчид (хувь хүн, аж ахуйн нэгж) зэргийг авч үзсэн байна.

Одоогийн байдлаар ТХБХМ нь хүсэлт гаргагч болон түүний харилцагчдыг эдгээр оролцогч талуудын хүрээнд авч үзэж, зөвхөн мэдээлэл өгөөд зогсохгүй төслийн үнэлгээний үе шатанд зөвлөлдсөн эсэхийг тодорхойлж чадахгүй байна. Хүсэлтэд дурдсан асуудалд банкны удирдлагын зүгээс өгсөн хариулыг харгалзан үзвэл төслийн хүрээнд оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг төслийн мөчлөгийн туршид хэрхэн явуулсан, хөдөлгөөний хязгаарлалт болон аюулгүй байдлын талаарх нөлөөллийг арилгах чиглэлээр харилцагчийн хүлээн авсан санал хүсэлтийг хэрхэн авч үзсэн талаар илүү гүнзгий судлах нь зүйтэй болно.

ОТОХТ нь төсөл ахихын хэрээр ашиглаж болох хэд хэдэн харилцааны аргуудыг жагсаасан байна. Гэсэн хэдий ч, харилцагч ТХБХМ-тай уулзах үедээ барилгын ажлын явцад гарч буй асуудлын талаар зөвхөн телевизийн мэдээгээр дамжуулж мэдээлдэг талаар дурдлаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хувьд, ОТОХТ-нд замын тэмдэг тэмдэглэгээ хийх шаардлагатай гэж тусгасан байна. Гэсэн хэдий ч, ТХБХМ төслийн газар дээр очиж ажиллахад ямар ч тэмдэг, тэмдэглэгээ олж хараагүй.

2014 оны БОНБ-ын ГШ10-ын 27-р заалтад, “хэрэв төсөлд нэмэлт сөрөг нөлөөлөл, эсвэл нөлөөлөлд өртсөн иргэдийн анхаарлыг татсан асуудалд хүргэх материаллаг өөрчлөлт гарсан бол харилцагч эдгээр нөлөөлөл, асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар мэдээлж, ОТОХТ-ний дагуу шинэчлэгдсэн БОНМТ-ийг ил болгоно. Иргэдэд үзүүлэх эдгээр нэмэлт сөрөг нөлөөлөл нь их байвал тухайн кейсээс хамааран тухайн харилцагч 16-аас 20-р заалтад заасны дагуу нэмэлт мэдээллийг ил болгож, талуудтай зөвлөлдөх шаардлагатай” хэмээн заасан байна.

I үе шаттай холбоотой замыг хаасан, ослууд гарсан гэх асуудал нь албаар биш ч гэсэн нөлөө болон үргэлжлэх хугацааны хувьд төсөлд ихээхэн өөрчлөлт гэж үзэхээр бөгөөд ийм өөрчлөлт нь нөлөөлөлд өртсөн ард иргэдэд нэмэлт нөлөөллийг бий болгосон болохыг үгүйсгэх аргагүй юм.

Энэ хүрээнд ЕСБХБ нөхцөл байдлын талаар хэзээ мэдсэн, ямар нэгэн арга хэмжээ авсан эсэх, мөн/эсвэл харилцагчаас мэдээлэл ил болгож, зөвлөлдөх талаар ямар нэгэн арга хэмжээ авахыг хүссэн эсэхийг тогтоох нь чухал юм. Гэнэт гурван гаруй зам хаасан, түр замуудын нөхцөл байдал тааруу, тэмдэг тэмдэглэгээгүй байгаа нь оролцоог хангах арга хэмжээг нэмэгдүүлэх нөхцөл үүссэн гэж ТХБХМ үзэхээр байна.

ТХБХМ шалгалтынхаа хүрээнд зам хаахын өмнө болон дараа/хаалттай байх үед ялангуяа холбогдох оролцогч талууд болон хүсэлтэд хөндөгдсөн асуудалтай холбогдуулан оролцогч талуудын оролцоог хэрхэн хангасан талаар авч үзэх юм. ТХБХМ нь үүнтэй холбогдуулан гомдол барагдуулах механизмын үйл ажиллагааг давхар судлах нь ач холбогдолтой гэж үзэж байна.

Иймээс, гомдол барагдуулах механизмыг энэ кейс дээр ашигласан эсэх, тус механизмыг байгуулж, ажиллуулж байсан эсэх, тухайн бизнес гомдол гаргаж байсан эсэх, эрх бүхий байгууллага нь гомдлыг хянан шийдвэрлэхээр хүлээн авсан, эсвэл ямар нэгэн алхам хийлгүйгээр хэрэгсэхгүй болгосон эсэх зэргийг ойлгох нь чухал юм.

3.5 Нөлөөлөлд өртсөн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар

Хүсэлт гаргагч нь харилцагчийн үйл ажиллагаа нь амьжиргаанд төдийгүй орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгаа талаар санаа зовниж байгаагаа "дутуу барьсан замаас болж олон хүний амь нас хохирч байна" хэмээн илэрхийлсэн байна.

ТХБХМ-ын комплайнсын үнэлгээний явцад хянаж үзсэн бичлэг, нийтлэл, захидал болон бусад баримт бичгүүд нь өмнөх үе шатуудад цуглуулсан материал, хамгийн чухал нь 2022 оны 7-р сард ТХБХМ-ын хийсэн газар дээрх айлчлалаас харахад Дарханы замыг тодорхой хугацаанд (2019 оны 8-р сараас 2022 оны 10-р сарын сүүлч) ашиглахыг хүссэн эсвэл ашиглах шаардлагатай хүн бүрийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх ноцтой, аюултай нөхцөл байдал үүссэн байгааг харуулж байна.²⁵

2014 оны БОНБ-ын ГШ4-т заасан зорилтуудын нэг нь, “төслийн амьдралын мөчлөгийн явцад төслийн нөлөөлөлд өртсөн иргэд болон хэрэглэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ердийн болон ердийн бус нөхцөл байдлаас үүсэх сөрөг нөлөөллийг урьдчилан таамаглах, үнэлэх, урьдчилан сэргийлэх буюу багасгах” юм.

Хаасан зам, түр замтай холбоотой аюулгүй байдлын асуудал нь иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм. Харилцагч түр замын аюулгүй байдлыг хангах үүрэгтэй²⁶. Үүнийг анхнаасаа авч үзсэн эсэх нь гол асуулт юм. Түүгээр зогсохгүй, зам хаагдах хугацаа сунжирсан нь түр замуудын нөхцөл байдлыг сайн нөхцөл байлгахыг баталгаажуулах хэрэгцээг нэмэгдүүлсэн бөгөөд үүн дээр мониторинг хийсэн эсэх асуудал нь хамгийн чухал юм.

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд дүн шинжилгээ хийх нь эдийн засгийн дайжилттай адилаар кейсийн нөхцөл байдлыг харгалзан үзэхэд онцгой төвөгтэй байх болно гэдгийг ТХБХМ тэмдэглэж байна. Учир нь үүнийг төслийн үнэлгээний үед тооцоолоогүй бөгөөд холбогдох байгууламжаас үүсэлтэй байгаа юм. Гэсэн хэдий ч зохих шинжилгээ хийж, судалж зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Иймээс, ТХБХМ нь энэ дэд хэсэгт дурдсан асуудлууд нь энэхүү тайлангийн өөр өөр хэсэгт тодорхойлсон бусад асуудлуудтай холбоотой болохыг мөн тэмдэглэж байна. Хавсаргасан ажлын даалгаварт дурдсанчлан, комплайнсын шалгалтын явцад янз бүрийн ГШ-уудын хоорондын боломжит холбоосыг шинжлэх шаардлагатай.

²⁵ Зам нээгдсэнээс хойш удаагүй хэдий ч аюулгүй байдлын нөхцөл сайжирсан талаар ямар нэгэн мэдээлэл энэ тайлангийн өдрөөр аваагүй байгаа болохоо ТХБХМ онцолж байна.

²⁶ ГШ 4-ийн 29-д заасны дагуу “харилцагч төслийн амьдралын мөчлөгийн туршид ажилчид болон иргэдэд учирч болзошгүй замын хөдөлгөөний болон замын аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлж, үнэлж, мониторинг хийнэ”.

Хавсралт 1. Комплайнсын шалгалтын ажлын даалгавар

Оршил

ЕСБХБ нь эдийн засгийн шилжилтийг дэмждэг гол хөрөнгө оруулагчийн хувьд бүх хөрөнгө оруулалтаа тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглүүлэх үүрэг хүлээдэг. Банкны төслүүдийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагаа нь ЕСБХБ-ны стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд банк нь төслүүдийг БОНБ-той нийцүүлэхийг шаарддаг. Нэмж дурдахад банк нь Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)-ын дагуу төслийн тодорхой мэдээллийг олон нийтэд мэдээлэх, ил тод, хариуцлагыг нэмэгдүүлэх, нөлөөлөлд өртсөн оролцогч талуудтай харилцах харилцааг сайжруулах, сайн засаглалыг дэмжих үүрэгтэй.

2019 оны ТХБ-д тусгасанчлан, ТХБХМ-ын зорилго нь төслийн оролцогч талуудын дунд нийгэм, байгаль орчны асуудал, мэдээллийг нийтэд ил болгохтой холбоотой асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, банк нь БОНБ, мөн МХБ-оо мөрдөж ажилласан эсэхийг тогтоох, мөн шаардлагатай тохиолдолд эдгээр бодлогыг зөрчихөөс урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ одоо байгаа аливаа зөрчлийг арилгах явдал юм. ТХБХМ-ын комплайнсын шалгалт нь харилцагч дагаж мөрдсөн эсэхэд **чиглэгдэхгүй** болно.

Хариуцлага

Комплайнсын шалгалтыг ТХБХМ-ын баг ТХБ-д тогтоосон бүрэн эрхийнхээ дагуу бие даасан, шударга, ил тод, урьдчилан таамаглах, шударга байх зарчмыг баримтлан явуулдаг. ТХБХМ нь шаардлагатай тохиолдолд техникийн асуудлаар зөвлөхүүдийг татан оролцуулж болох боловч комплайнсын шалгалтын тайланг гаргах үүрэг ТХБХМ-д үлдэх бөгөөд комплайнсын шалгалтын дүр дүнд үндэслэн комплайнсын шалгалтын дүгнэлтийг тус албаны дарга гаргана.

Хамрах хүрээ

Энэхүү ажлын даалгаврыг **кейс 2022/01** хүсэлтэд үндэслэн боловсруулсан бөгөөд **Улаанбаатар-Дарханы зам (50766)** холбогдуулан тус банк 2019 оны ТХБ-ын 2.7 (а)-д заасны дагуу өөрийн үйлдэл, эс үйлдлээрээ дамжуулан 2014 оны БОНБ-ыг зөрчсөн эсэхийг тогтоох зорилготой комплайнсын шалгалтын хүрээнд ТХБХМ-аас авч хэрэгжүүлэх аливаа судалгаа, арга хэмжээ, хяналт шалгалтын үйл ажиллагаанд хамаарна.

Комплайнсын шалгалтын хамрах хүрээг доор дурдсан бөгөөд энэ нь тодорхой ГШ-д хамаарах боловч олон ГШ-уудын хоорондын боломжит уялдаа, холбоос (мөн цаашид бусад ГШ)-ыг нэмж авч үзэх болно.

Шалгалтын хамрах хүрээ нь зам хаагдсан, түр замын аюулгүй байдал хангагдаагүйгээс үүдэн эдийн засгийн дайжилт үүссэн гэх гомдолд хамаарах 2014 оны БОНБ-ын Гүйцэтгэлийн шаардлага 1, 4 болон 10-д заасанчлан үүргээ ЕСБХБ-биелүүлсэн эсэхийг хянаж үзэхэд хамааралтай болно. ТХБХМ-ын I үе шаттай холбоотой шалгалтын хамрах хүрээ нь холбогдох байгууламжтай холбогдуулан заасан 2014 оны БОНБ-ын үүргүүдээр хязгаарлагдах болно.

Ерөнхий

ЕСБХБ нь төслийн дизайныг боловсруулж, хэрэгжүүлэхдээ холбогдох зохицуулалтын шаардлага, олон улсын сайн туршлага (ОУСТ)-ыг авч хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах байгаль орчин, нийгмийн үнэлгээ, мониторингийн үйл явцыг ашиглахыг эрмэлзсэн эсэх?

ЕСБХБ-ны төслийн үнэлгээ, төслийн шаардлага, мониторингийн нэгдсэн арга барилыг тохиролцохын тулд АХБ-тай хамтран ажилласан бол хэр хэмжээнд хамтран ажиллахыг эрмэлзсэн байна вэ? (2014 оны БОНБ-ын 16-р дэд хэсэг).

ЕСБХБ-ны байгаль орчин, нийгмийн үнэлгээнд ЕСБХБ-наас санхүүжүүлээгүй ч гэсэн төсөлтэй холбогдох байгууламж, үйл ажиллагааг зохих хэмжээнд харгалзан үзсэн үү? (2014 оны БОНБ-ын 30-р дэд хэсэг)

ГШ 1: Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, асуудлын үнэлгээ, менежмент:

- Байгаль орчин, нийгмийн үнэлгээний үйл явц нь төслийн нэг хэсэг биш боловч төсөлд шууд болон шууд бусаар нөлөөлж болзошгүй үйл ажиллагаа эсхүл зөвхөн төслөөс үүдэн оршин тогтнож буй эсвэл төсөлд эрсдэл учруулж болзошгүй (энэ нь I үе шаттай холбоотой байгууламжууд юм) байгууламжтай холбоотой байгаль орчин, нийгмийн чухал ач холбогдолтой асуудлуудыг зохих хэмжээгээр тодорхойлж, холбогдох онцлогийг тусгасан уу?
- ЕСБХБ нь төслийн эхлэл/үнэлгээний явцад болон хүсэлтэд тавигдсан асуудлуудыг олж мэдмэгцээ төсөлтэй холбоотой боловч төслийн нэг хэсэг биш үйл ажиллагаандаа ГШ болон ОУШТ-д нийцсэн байдлаар байгаль орчин, нийгмийн эрсдэлийг удирдахын тулд харилцагчтай хэрхэн хамтран ажилласан бэ?
- Банк мониторинг хийх явцдаа зам урт хугацаагаар хаасан, түр замын нөхцөл байдал муу байгаагаас оролцогч талуудад үзүүлэх нөлөөллийн ач холбогдол үүссэнийг үнэлсэн үү? Хэрэв тийм бол банк харилцагчаас нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг багасгах, нөхөх арга хэмжээ авахыг шаардсан уу?
- ЕСБХБ нь тухайн газар дах аж ахуйн нэгжид нэвтрэхэд асуудал гарч болох, түр зуурын эдийн засгийн дайжилт үүсэх эрсдэлтэй эсэхийг харгалзаж үзсэн үү?

ГШ 4: Эрүүл мэнд, аюулгүй байдал

- Харилцагч нь төсөлтэй холбоотой эрсдэл, нөлөөлөлд өртсөн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлж, үнэлж дүгнэж, нөлөөлөл, эрсдэлийн хэмжээнд тохирсон, төсөл болон түүнтэй холбоотой байгууламжуудын үе шат, хамрах хэмжээ, шинж чанарт тохирсон хамгаалалт, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг боловсруулах шаардлагатай байсан уу??
- Харилцагч нь төслийн амьдралын мөчлөгийн туршид нөлөөлөлд өртөж болзошгүй орон иргэдийн замын хөдөлгөөний болон замын аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, мониторинг хийх, шаардлагатай тохиолдолд тэдгээрийг арилгах арга хэмжээ, төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байсан уу?

- Харилцагч нь төслийн үе шат бүрд замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийж, аваар ослын тайланд тогтмол хяналт тавьж, I үе шатны холбогдох байгууламжтай холбоотой асуудал эсвэл аюулгүй байдлын сөрөг хандлагыг тодорхойлж, шийдвэрлэх шаардлагатай байсан уу?

ГШ 10: Мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын оролцоо

- ЕСБХБ нь үе шатуудын хүрээнд харилцагч оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг явуулахдаа ерөнхий төслийн шууд нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд болон бусад холбогдох оролцогч талуудад цаг тухайд нь, хамааралтай, ойлгомжтой, хүртээмжтэй мэдээллийг соёлд тохирсон, заль мэх, хөндлөнгийн оролцоо, албадлага, айлган сүрдүүлгээс ангид байдлаар хийсэн эсэхийг баталгаажуулсан уу?
- Үе шатуудын хүрээнд оролцогч талуудын оролцоог хангах ажиллагаанд дараах элементүүд багтаасан уу, үүнд: оролцогч талуудыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх; оролцогч талуудын оролцоог төлөвлөх; мэдээллийг ил болгох; зөвлөгөөн ба оролцоо; гомдол барагдуулах механизм; болон холбогдох оролцогч талуудад тайлагнаж байгаа эсэх?
- Төслийн эрсдэл, нөлөөлөл, боломжуудыг оролцогч талуудад ойлгуулахад туслах төслийн мэдээллийг ил болгох ажлыг харилцагч хөнгөвчилж өгсөн үү?
- Харилцагч нь оролцогч талуудын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэхэд, ялангуяа харилцагчийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны талаарх гомдлыг шийдвэрлэхэд үр дүнтэй гомдол барагдуулах механизм, үйл явц эсвэл журмыг бий болгосон уу?
- Энэхүү гомдол барагдуулах механизмыг ашигласан эсэх, ЕСБХБ үүнийг ашиглах боломжтой, ажиллагаатай байгааг баталгаажуулсан эсэх, хэрэв хүсэлт гаргагчийн гаргасан гомдол байгаа бол эрх бүхий байгууллага үүнийг гомдол хэмээн хянан шийдвэрлэх боломжтой гэж үзсэн эсвэл ямар нэг алхам хийлгүйгээр зүгээр л хэрэгсээгүй уу?
- ЕСБХБ нь хүсэлт (жишээ нь, зам удаан хаасан, түр замын хангалттай бус, түүнтэй холбоотой осол аваар) болон үүнээс үүдэн гарсан гэнэтийн бөгөөд томоохон өөрчлөлтийн талаар мэдмэгцээ ямар нэгэн арга хэмжээ авч мөн/эсвэл харилцагчаас ямар нэгэн арга хэмжээ авахыг хүссэн үү? Ялангуяа, ЕСБХБ нөлөөлөлд өртсөн ард иргэдийг хангалттай мэдээлэлтэй байлгахыг баталгаажуулсан уу? БОНМТ-г шинэчиж гаргасан уу? I үе шатны холбогдох байгууламжтай холбоотой бүтээн байгуулалтын үргэлжлэх хугацаа, цар хүрээ, хүндрэлийн зэргийг харгалзан нэмэлт тодруулга хийх, зөвлөлдөх шаардлагатай байсан уу?

Комплайнсын шалгалтын арга зүй

Комплайнсын шалгалт нь дараах үйл ажиллагааг багтаана. Үүнд:

- а. Шаардлагатай бол, комплайнсын баг төслийн сайтад зочлох;
- б. Төслийн холбогдох файлуудыг хянан үзэх (төслийн баримт бичиг, судалгаа, тэмдэглэл, цахим шуудан болон ТХБХМ-ын хамааралтай гэж үзсэн бусад файлууд);

с. виртуал/биечлэн ярилцлага хийх (ТХБХМ-тай холбогдох боломжтой бол):

- банкны удирдлага;
- төсөлд оролцсон зөвлөхүүд;
- хүсэлт гаргагч болон төслийн нөлөөлөлд өртсөн бусад хүмүүс
- харилцагч;
- АХБ-ны ажилтнууд; мөн
- ТХБХМ-ын хамааралтай гэж үзсэн бусад гуравдагч этгээд.

d. ТХБХМ-ын шаардлагын дагуу техникийн оролцоог хангахын тулд шаардлагатай тохиолдолд зөвлөхүүд эсвэл техникийн мэргэжилтнүүдийг авч ажиллуулна, мөн

e. ТХБХМ нь ажлаа явуулахад тохиромжтой гэж үзсэн бусад хяналт, шалгалтын арга.

Хүсэлт гаргагч нь АХБ-ны комплайнсын шалгалтын багт гомдол гаргахаар шийдсэн тохиолдолд ТХБХМ нь ТХБ-ын 3.1 заалтад заасанчлан давхардсан үйл явц, хэт их саатал үүсэх эсвэл бүх талуудад саад, төвөг учруулахаас зайлсхийн кейсийг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд АХБ-ны комплайнсын шалгалтын багтай нягт уялдаатай харилцах бөгөөд хамтран ажиллах боломж байгаа эсэхийг авч үзнэ.

Мэргэшсэн хүний нөөц

ТХБХМ нь комплайнсын шалгалтын техникийн зарим асуудалд туслалцаа авахаар тусгай экспертүүд ажиллуулахыг шаардаж магадгүй юм. Урьдчилсан байдлаар ТХБХМ нь олон улсын сайн туршлагын дагуу кейсийг шалгахад туслах тээврийн мэргэжилтнээс техникийн дэмжлэг шаардаж болохоор байна. Шалгалтын явцад орчуулагч, хэлмэрчид авч ажиллуулах шаардлагатай.

Хугацаа

Комплайнсын шалгалт нь энэхүү ажлын даалгаврыг агуулсан комплайнсын үнэлгээний тайланг ТХБХМ-д кейс бүртгэл систем дэхь кейс файлд цахимаар байршуулсны дараа нэн даруй эхлэх болно.

Одоогийн байдлаар ТХБХМ нь дараах шалтгааны улмаас комплайнсын шалгалтын тайлангийн төслийг гаргасан байх хугацааг тодорхой товлох боломжгүй байна, үүнд: комплайнсын багийн одоогийн ажлын ачаалал, материал орчуулахад шаардагдах хугацаа; мөн 2023 оны 5-р сараас 8-р сарын хооронд төслийн сайтад биечлэн очиж ажиллах шаардлага үүсэх зэрэг болно. Тухайн нөхцөлөөс хамааран комплайнсын шалгалтыг аль болох шуурхай явуулахын тулд бүхий л хүчин чармайлт гаргана.

ТХБХМ нь комплайнсын шалгалтын тайлангийн төсөл бэлэн болмогц хүсэлт гаргагч, удирдлага, харилцагчтай нууцын баталгаатай хуваалцаж, тэдний саналыг авч, түүний дараа тайланг эцэслэх болохыг анхаарна уу.

ТХБХМ нь комплайнсын шалгалтын тайланг эцэслэн гаргахад хоёр боломжит үр дүнгийн аль нэг гарна.

1. Хэрэв банк зөрчил гаргаагүй гэж тогтоогдвол нэмэлт арга хэмжээ авах шаардлагагүй. Комплайнсын шалгалтын тайланг Захирлуудын зөвлөлд мэдээлэл болгон хүргүүлж, ТХБХМ-ын кейс бүртгэлд ил болгож, кейсийг хаана.
2. Хэрэв банк **зөрчил гаргасан** нь тогтоогдвол, комплайнсын шалгалтын тайланг Захирлуудын зөвлөлд хүргүүлж, олон нийтэд ил болгохоос өмнө хэд хэдэн алхам хийх ёстой. Энэ процесс нь комплайнсын шалгалтын тайланг эцэслэн гаргасан өдрөөс хойш 6 сар орчим үргэлжлэх бөгөөд дараах алхмуудыг багтаана. Үүнд:
 - a. Комплайнсын шалгалтын тайланд төслийн болон системийн түвшний зөвлөмжүүд багтана.
 - b. Банкны удирдлагаас Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулна.
 - c. Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хүсэлт гаргагчид илгээнэ.
 - d. Удирдлага нь Хүсэлт гаргагчийн саналыг хянаж, шаардлагатай гэж үзвэл төлөвлөгөөнд өөрчлөлт оруулна.
 - e. ТХБХМ нь комплайнсын шалгалтын тайлан болон Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Захирлуудын зөвлөлд илгээнэ - энэ шатанд Захирлуудын зөвлөлөөс төлөвлөгөөг хянаж, батална эсвэл Удирдлагад буцааж илгээнэ.
 - f. Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсаны дараа ТХБХМ нь комплайнсын шалгалтын тайлан, Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөг ил болгож, мониторингийн үе шатыг эхлүүлнэ.

Хугацаа сунгалт

Хэрэв ТХБХМ энэ хугацааг сунгах шаардлагатай бол талуудад нэн даруй мэдэгдэх бөгөөд кейсийн бүртгэлийн системд шинэчлэгдсэн хугацааг бүртгэнэ.

Хүсэлт гаргагч эсвэл удирдлага сунгах хугацаа сунгах шаардлагатай гэж үзвэл санал болгож буй сунгасан хугацааны хамт хүсэлтээ ТХБХМ-д мэдэгдэх ёстойг анхаарна уу. ТХБХМ эдгээр хүсэлтийг хүлээн авч, шийдвэрийнхээ талаар бүх талуудад шуурхай мэдээлэх болно.

Урьдчилсан хуваарь

Хэрэгжүүлэх гол үе шатуудын урьдчилсан хуваарийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Үйл ажиллагаа	Тооцоолсон хугацаа ¹
Комплайнсын шалгалт хийж, комплайнсын шалгалтын тайлангийн төслийг бэлтгэх Баримт, материал судлах Холбогдох баримт бичиг, судалгааг тодорхойлох, эмхэтгэх. (Англи хэл рүү орчуулга хийж болно), мөн ярилцлагад оролцогчдыг тодорхойлох Ярилцлагад хамрагдах холбогдох оролцогч талуудыг тодорхойлох Хэлэлцүүлэг, ярилцлага (шаардлагатай бол виртуалаар эсвэл биечлэн, мөн хөл хорионы арга хэмжээнд нийцүүлэн) Шаардлагатай бол, сайтаар зочлох (огноог баталгаажуулах шаардлагатай) Комплайнсын шалгалтын тайлангийн төсөл ТХБХМ тайлангийн төслийг хүсэлт гаргагч, удирдлага, харилцагчид хүргүүлнэ. Хэрэв ТХБХМ банкийг зөрчил гаргасан гэж үзвэл, комплайнсын тайланд зөрчлийг шийдвэрлэх зөвлөмжийг багтаасан байна; түүнчлэн Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэж, баталсны дараа Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөний мониторинг эхэлнэ	2023 оны дөрөвдүгээр сар - 2023 оны арван хоёрдугаар сар 2023 оны зургадугаар сараас наймдугаар сарын хооронд Тайлангийн төслийг боловсруулж дуусгах урьдчилсан огноо нь [2023 оны арван хоёрдугаар сар]. Талуудад хуваалцсаны дараа тэд ажлын 10 өдөрт комплайнсын шалгалтын тайлангийн төсөлд бичгээр саналаа өгнө.
Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах Удирдлага нь зөрчсөн гэх дүгнэлтийн дагуу Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна. Мөн хэрэв шаардлагатай гэж үзвэл комплайнсын шалгалтын тайлангийн үр дүнгийн талаар Удирдлагын хариуг бэлтгэж болно. Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд хүсэлт гаргагчийн санал авахаар хувцаалах. Комплайнсын шалгалтын тайланг эцэслэх ТХБХМ нь Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд хүсэлт гаргагчийн саналыг авч үзсэний дараа комплайнсын шалгалтын тайланг эцэслэн гаргана. Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэн боловсруулах	Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг ТХБХМ-д хүргүүлэх – Хүсэлт гаргагчийн тайлбарыг ТХБХМ-д ирүүлэх Комплайнсын шалгалтын тайлангийн төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоног ТХБХМ-с тарааснаас хойш ажлын 20 хоног Комплайнсын шалгалтын тайлангийн эцсийн хувилбар, хүсэлт гаргагчийн УҮАТ-нд өгсөн саналыг Удирдлагад хүргэх Санал хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоног Удирдлагын үйл ажиллагааны эцсийн төлөвлөгөө Комплайнсын эцсийн шалгалтын тайлан болон хүсэлт гаргагчийн тайлбарыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 хоног
Хэрэв ТХБХМ банк зөрчил гаргаагүй гэж үзвэл ТХБХМ нь талуудын саналыг үндэслэн комплайнсын шалгалтын тайланг эцэслэн боловсруулж, Захирлуудын зөвлөл, Ерөнхийлөгчид танилцуулж, кейс бүртгэлийн системд ил болгож, кейсийг хаадаг.	Комплайнсын шалгалтын тайланг эцэслэн шийдвэрлэсний дараа шууд олон нийтэд мэдээлэх.
Комплайнсын шалгалтын баримт бичгийг ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөлд хүргүүлэх ТХБХМ нь эцсийн комплайнсын шалгалтын тайлан, удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө, хүсэлт гаргагчийн саналыг хүргүүлнэ. Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөг Захирлуудын зөвлөлд оруулж шийдвэрлүүлэх бол зөрчилгүй тохиолдолд холбогдох баримт бичгүүдийг Захирлуудын зөвлөлд мэдээлэл болгон хүргүүлнэ.	Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөг Захирлуудын зөвлөлийн шийдвэрлүүлэх - Захирлуудын зөвлөлийн хуваарийн дагуу Батлагдсан Удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөг багтаасан комплайнсын шалгалтын багц баримт бичгийг нийтэд мэдээлэх – УҮАТ-г баталсны дараа

¹ Үйл ажиллагаа болон/эсвэл үр дүнд хүрэх эцсийн хугацааг бодлогод заасан хугацааны дагуу тооцсон.

Мэдээлэлд хандах

Энэхүү комплайнсын шалгалтыг цаг тухайд нь дуусгахын тулд ТХБХМ нь банкны удирдлагаас холбогдох банкны ажилтнууд болон файлд бүрэн, хязгаарлалтгүй хандахыг шаардлагатай. Холбогдох талууд ТХБХМ сайтад нэвтрэх, бичгээр материал ирүүлэх, мэдээлэл өгөх, хуралд оролцох хүсэлтийг биелүүлэхийг уриалж байна. Комплайнсын шалгалтыг явуулахад аль нэг талын үйлдэл, эс үйлдэл, мөн саатуулах, хойшлуулах аливаа нөхцөл байдлыг комплайнсын шалгалтын тайланд дурдаж болно.

Комплайнсын шалгалтын явцад ТХБХМ-ын цуглуулсан аливаа мэдээлэлд хандах, ашиглах, задруулах нь тус банкны Мэдээллийн хүртээмжийн бодлого болон арилжааны болон/эсвэл бусад нууц мэдээллийг хамгаалахад тавигдах бусад шаардлагуудын дагуу явагдана. ТХБХМ нь тухайн баримт бичгийг эзэмшигчийн бичгээр зөвшөөрөл авалгүйгээр нууцлахаар тохиролцсоны үндсэн дээр өгсөн аливаа баримт бичиг, мэдээллийг бусдад задруулахгүй.